

БАГШИЙН ЁС ЗҮЙН АСУУДАЛ БОЛОВСРОЛЫН СИСТЕМД НӨЛӨӨЛӨХ НЬ

IMPACT OF TEACHER ETHICS ON THE EDUCATION SYSTEM

Ц.Өнөболд

Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн багш, цагдаагийн ахлах дэслэгч

Хураангуй: Боловсролын салбарын тулгамдаж буй асуудлын нэг болох багшийн ёс зүйн тухай онолын мэдээлэл ба судалгааны ажилд тулгуурлан багшийн ёс зүйн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тайлбарлахад оршино.

Түлхүүр үг: Багш мэргэжил, ёс зүй, багшийн үүрэг, сурагчид, үлгэр дуурайлал

Удиртгал

Аливаа зүйлийг гүн гүнзгий ойлгож, бүхнээс илүү мэдлэг чадвараараа ялгарч, явсан газар бүхнээ шинэ мэдлэг, шинэ уур амьсгал, ажлын шинэ үүсгэл санаачилгыг өрнүүлж байдаг хүмүүс гэж багш хүнийг манай ард түмэн хүндэтгэн дээдэлдэг. Сургаж хөгжүүлэх ажлыг өдөр цаг тутам гардан зохион байгуулж байгаа багш хүн өөрийн ажилдаа ямагт дүн шинжилгээ хийж юу нь болж, юу нь болохгүй байгааг тунгаан бодож цаашид хийх ажил арга зүйгээ оюун ухаандаа төсөөлөн, бодож мөрддөг байх нь сайн багш болохын үндэс юм. Багш мэргэжил бол нийгмийг бүрдүүлэгч анги давхаргыг өөр хооронд холбох гүүр төдийгүй хувь хүн бүрийн ирээдүйн хөгшлийн замыг заагч хөтөч мөн. ЗХУ-ын нэрт сурган хүмүүжүүлэгч В.А Сухомлинский өөрөө өөртэйгээ ярьж, өөрийн мөс, чанарын тухай бодож үзэх гэдэг бол оюун санааны амьдралын дээд шат, хүн төрөлхтний ёс суртахууны баялаг дотор өөрийнхөө байр суурийг олж авах шат мөн хэмээжээ. Үнэхээр багш мэргэжил бол энэ нийгмийн сор болсон мэргэжил төдийгүй манай улсын ирээдүйн хөгжлийг тээгч цогц чадамж юм. Багш хүн ажилдаа эзэн болж, ажилдаа гаршиж дадлагажих ёстой, орчин үеийн багш нар байнга хөгжиж, мэдлэг чадвар, хандлагаа өөрчлөхгүй бол бүх зүйл маш хурдацтай хөгжиж байгаа. ХХI зууны багш бол судлаач багш болж байгаа. Багш нар сурагчаа судална, өөрийнхөө хичээлийг судална, өөрийгөө, хөдөлмөрөө ч судлах ёстой. Мөн өнөө цаг үед багшийн ёс зүйн тухай асуудал боловсролын системд нэн чухлаар яригдах болсон билээ.

Зорилго

Боловсролын салбарын багш мэргэжилтний ёс зүй гэж юу болох, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар судлан шинжилж, багшийн ёс зүйн талаар үнэлгээ дүгнэлт гаргах

Зорилт

Багшийн хөгжлийн эхлэл суурь болох ёс зүйн талаар судлан шинжлэх

Багшийн ёс зүйд юу юу хамаарах талаар судалгааны ажлыг өрнүүлэх

Багшийн хөгжлийг илэрхийлэх гол хүчин зүйлүүд ба багш хэрхэн ёс зүйтэй байх талаар өөрийн үзэл бодлыг илэрхийлэх

Багшийн ёс зүй

Багш мэргэжлийн үнэ цэнэ бол хүнийг хараад таних улмаар хүүхэд, залуустай болон бусадтай зөв боловсон ёс зүйтэй харилцах явдал мөн. Өөрөөр хэлбэл багшийн үнэ цэнэ нь харилцаагаар илэрхийлэгддэг гэж ойлгож болно. Мундаг сайн мэдлэгтэй багш байлаа гээд харилцааны эв дүй муутай бол тэрбээр өөрийн эргэн тойрны хүмүүсийн итгэлийг дааж чадахгүй төдийгүй шавь нараа үнэлэгдэж чадахгүй юм. Бас багш хүн хүүхэд залуусын хамтрагч ба зөвлөгч байх ёстой гэсэн багш хүний үнэт хэм хэмжээг даган биелүүлж чадахгүй. Тиймээс багш хүн хамгаас түрүүн харилцааны ур чадвар дээр маш сайн анхаарах хэрэгтэй. Багш хүний үнэ цэнийн илэрхийлэгч гол хүчин зүйл бол харилцаа. Харилцааны мөн чанар бол бусдыг хүндэтгэх, нийгэмд эерэг байдал түгээх явдал хэмээн ойлгож болох бөгөөд боловсон ёс журам хүүхэд ахуйгаас гэр бүлийн дотор үүсэж бүрэлддэг. Хүмүүс бид хүүхэд байхаасаа «баярлалаа», «зүгээр», «уучлаарай» гэх зэрэг үгийг сонсож мэдээд амьдралынхаа туршид хэрэглэж ирдэг. Эдгээр үгс хүмүүсийн хоорондын харилцааг сайн сайхан болгон чимж тэднийг улам эелдэг боловсон болгодог төдийгүй үүний ачаар нэг хүн баярласан талархсанаа илэрхийлж, нөгөө хүн чин сэтгэлийн энэхүү хөдөлгөөнийг ойлгон мэдэрдэг билээ.

Ёс зүй нь гүн ухааны нэгэн салбар бөгөөд ёс зүйн талаар асуултуудыг судлана. Ёс зүй хэмээх ойлголт нь эртний грекийн Ethos буюу хамтран амьдрах, оршин амьдрах газар гэдэг утгатайгаар илэрхийлэгддэг байсан. Хожим нь хөгжлийн явцад “ёс заншил, зан төлөв, зан араншин, сэтгэлгээний хэв маяг” гэсэн агуулгатай болж, тэдгээрийн шинж чанарыг илэрхийлэх болсон. Аристотель хүний зан төлөвийн өвөрмөц шинжийг илэрхийлэхийн тулд “Этос” гэх ойлголтыг анх хэрэглэсэн. Монголчуудийн хувьд ёс зүй буюу ёс суртахуун бол хүн нийгэмд хэрхэн биеэ авч явах, юуг яаж хийх бичигдээгүй дүрэм, журам юм. Ёс суртахууны үндсэн дөрвөн зарчим байдаг. Эдгээр нь бусдыг үл хорлон буяныг үйлдэх, бусдад хүч үл хэрэглэн эвийг хичээх, үл бузарлан сэтгэлийг ариусгах, аливаад үл булхайдан шударгыг эрхэмлэх юм.

Ёс зүй нь нийгэм хүмүүнлэгийн аль ч ухаанаас илүүтэйгээр нийгмийн амьдрал, хүний үйлдэл, үйл ажиллагаа, харилцаатай нягт холбогддог онцлогтой. Ёс суртахуун улс төрийн харилцаанд хүмүүнлэг ба хүмүүнлэг бус, эдийн засгийн харилцаанд шударга ба шударга бус, оюун санааны харилцаанд үнэнч ба үнэнч бус чанараар илэрч байдаг. Ёс суртахуун нь хүмүүсийн зайлшгүй баримталж хэрэгжүүлэх зарчим, дагаж мөрдөх зүй зохистой хэм хэмжээ юм. Ёс суртахуунлаг байна гэдэг нь зөвийг сурах, түүнийгээ өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаандаа байнга мөрдөж хэвшүүлнэ гэсэн үг. Харин хүний ёс журам, заншил сурталд нийцүүлж чадахгүй үйлийг “ёсгүй” хэмээн тодорхойлсон байдаг. Ёс суртахууны үйлдэл нь тодорхой зорилготой байхаас гадна ёс суртахууны алтан зарчмын дагуу хэрэглэнэ. Ёс зүй бол тухай орны ард түмний зан заншил, харилцаанд бичигдээгүй хууль маягтайгаар тогтсон хариуцлагын хэм хэмжээ юм. Өөрөөр хэлбэл тодорхой ажил үйлс эрхэлж байгаа хүний зүгээс нийгэмтэйгээ харилцах, хариуцлага хүлээх, олны дунд биеэ авч явах, хүнтэй харилцах соёл сайн сайхан зан үйлийн уламжлалт хэм хэмжээний нэгдмэл системийг хэлдэг гэж болох мэт.

Багш хүн хүний оюун сэтгэхүйтэй ажилладаг учраас шавь нарынхаа хэн болохыг харцнаас нь, сэтгэл санаанаас нь, мэдлэг чадвараас нь, харилцаа хандлагаас нь “уншиж” судалж, шинжилж, зөв оношилж, ажиллах арга эвээ өөрөөс нь олж авдаг. Багштай хэрхэн харилцах нь хүүхдэд багш яаж хандаж түүний сайн сайхны төлөө сэтгэлээ хэрхэн хандуулж анхаарал халамж тавьж байгаагаас хамаардаг. Хүүхдийг зэмлэх, буруушаах талыг өрөөсгөл барьж “Багш бол багш л байх ёстой” гэж хандаж харилцах нь сурган хүмүүжүүлэх харилцаа зөрчигдөхөд хүргэх нь олонтаа. Хүүхэдтэй харилцахад хэм хэмжээнээсээ хэтэрсэн аливаа хандлага тэдний зүгээс сөрөг хандлага, дургүйцэлтэй заавал тулгардаг болохыг эрдэмтэд тодорхойлсон нь буй.

Польшийн нэрт сурган хүмүүжүүлэгч Януш Корчакийн нэгэн тэмдэглэлд хүүхдийн оюуны ертөнцийг хүндэтгэх, харин тэгэхдээ хүлцэнгүй хандахгүй байх тухай дурдсан байдаг. Энэ бол тун нарийн утга санаа бөгөөд түүний мөн чанарт багш бид нар гүнзгий нэвтрэх хэрэгтэй. Хүүхдийг хөхүүлэн магтахгүйгээр, түүний ямар нэгэн содон чанарыг тодруулахгүйгээр, орчин тойрныхоо бодит байдалыг өвөрмөц хэлбэрээр ялгаж тодруулах хүүхдийн ухаарал, сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл тэдний хүртэхүйн ертөнцийг ойлгохгүйгээр жинхэнэ сурган хүмүүжүүлэгч болж чадахгүй. Хүүхдийн оюуны ертөнцийг хүндэтгэх гэдэг үзэл нь ертөнцийг зүрх ба ухаанаараа танин мэдэх явдал гэж ойлгох хэрэгтэй.

Оросын сэтгэл зүйч Д.Париган “Харилцах процесс нь хүмүүс хоорондоо харилцан үйлчлэлцэх, мэдээлэл дамжуулан солилцох, найз нөхдийн хувьд хүмүүс бие биендээ хандах, харилцан бие биедээ нөлөөлөх, хэн хэнийхээ сэтгэл санааны байдлыг мэдэрч хуваалцах, харилцан ойлголцох зэрэг олон асуудлыг нэгэн зэрэг

илэрхийлж байдаг” гэж тодорхойлсны зэрэгцээ шинжлэх ухааны үүднээс харилцааг олон янзаар тодорхойлсон байдаг. Жишээ нь :

-Харилцаа нь амьд ахуйн үндсэн нөхцөл юм.

-Харилцаа бол хүмүүсийн дотоод сэтгэлийн хэрэгцээ юм.

-Харилцаа нь хүмүүсийн сэтгэл хөдөлгөөний илэрхийлэл мөн.

-Харилцаан хүмүүсийн хоорондын энергийн харилцан солилцоо мөн.

-Харилцаа нь харилцан нөлөөлөл юм.

-Харилцаа бол харилцагч хүнээ таних, судлах арга болдог.

-Харилцаа нь бие хүнийг төлөвшүүлэх хэрэглүүр мөн.

-Харилцаа бол соёл юм гэх мэтээр харилцааг олон талаас тодорхойлж хүн төрөлхтний хөгжил дэвшилд харилцааны мөн чанарыг ойлгож ухаарах явдал нь нэн чухал боллхыг харуулж өгчээ.

Харилцааны бүтэц нь хэлхээ холбоо тогтоох буюу харилцагчдын хооронд мэдээлэл солилцох үйл явцыг багтаасан харилцааны явцуу утга, харилцагчдын хооронд мэдээлэл, үзэл санаагаа солилцохын зэрэгцээ үйлдэл солилцох, харилцан үйлчлэх, харилцаанд оролцогчид бие биенээ хүндлэн хүлээн авахдаа харилцан ойлголцлыг төрүүлэх мэдрэхүйн хэсгүүдээс бүрдэнэ. Өөрөөр хэлбэл харилцааны мөн чанар гэдэг бол асар их мэдрэмж шаардах үзэгдэл хэмээн ойлгож болно. Харилцааны мөн чанарыг ойлгож ухаарч түүнд суралцсанаар хүмүүсийн харилцааны доголдол ба сөрөг шинжүүдийг олж харан тэдгээрийн эерэг аргаар шийдвэрлэх арга замд ч суралцах юм. Харилцаа гэдэг бол хүний амьдралын бүхий л үйл явцын тасралтгүй үргэлжлэл бөгөөд нийгмийн аль ч хэсэгт зайлшгүй харилцааны идэвхтэй байдал нв хүнийг хөгжихөд, нийгэмшихэд гол нөлөөлөл болдог. Эсрэгээрээ харилцааны идэвхтэй байдал үгүй бол хөгжил гэж үгүй. Иймээс сурган хүмүүжүүлэгч багш хүн харилцааны олон зөв дадал хэвшлийг өөртөө төлөвшүүлж ямар ч нөхцөлд байдалд зөв харилцаагаараа нийгэмд үлгэрлэсэн ёс зүйтэй багш хүн байх ёстой.

Багшийн эцэг эхтэй хамтран ажиллах үйлийн сэтгэл зүйн үндэс: Гэр бүл бол хүүхэд, залуусын хөгжлийг тэтгэгч анхдагч орчин бөгөөд хүүхэд хамгийн чухал дэмжлэгийг гэр бүлээсээ л авч байдаг ба түүний хөгжилд эцэг эхийн оролцоо хэдийчинээ их байх тусам бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийн үзүүлэлт нь төдийчинээ дээшилдэг байна. Гэвч дийлэнх эцэг эхчүүдэд хүүхдийнхээ хөгжлийг дэмжих арга замаа олоход бэрхшээл тохиолддог тул тэдэнд сурган хүмүүжүүлэх ур чадвараа хөгжүүлэх хэрэгцээ байнга үүсч байдаг. Тиймээс багш хүн эцэг эхтэй ажиллах арга барицыг сайтар эзэмшиж, эцэг эх, хүүхэд, багшийн гурвалсан харилцааг үүсгэж сургалтын хэлбэрийг зохион байгуулж,

хичээлээс гадуурх үйл ажиллагааг идэвхтэй өрнүүлэх нь бие хүний хөгжил төлөвшил болон хүүхэд, залуусд нийгэмшлийг олоход маш чухал нөлөө үзүүлдэг.

Сэтгэл судлалын шинжлэх ухаан нь олон зууны туршид хөгжингүй болон боловсорсоор ирсэн бөгөөд энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийж, санал бодлоо тусгасан эрдэмтэд ч олон билээ. Дэлхий нийтээр хүлээн зөвшөөрдөг ганц зүйл бол хүүхэд, залуусын хөгжил төлөвшилд нийгэм буюу хүрээлэн буй орчин хамгаас чухлаар нөлөөлдөг гэх үзэл санаа билээ. Хүрээлэн буй орчин гэдэгт хамгаас түрүүн гэр бүл ба сургуулийн орчин хамаарагдана. Гэр бүлийн бүхий л гишүүд мөн сургуулийн багш ажилчин бүр хүүхдийн хөгжлийн толь болж байдаг. Үүнийг багш хүн сайтар ухаарч эцэг эхтэй хамтран ажиллах тал дээр санал бодлоо тусган мөн туршлага бүхий бусад багш нараасаа туршлага солилцох нь хүүхдийн ирээдүйн хөгжилд болон багш хүний ажлын ахиц дэвшилд эерэг нөлөө үзүүлэх юм.

Мөн багш хүний хамгийн сайн анхаарах зүйлийн нэг бол сурагч нэг бүрийг судалж бас сурагч нэг бүрийн ар гэрийн байдлыг таньж мэдэх нь чухал. Өнөөгийн байдлаар эцэг эхчүүдийн хүүхэддээ анхаарал хяналт тавих хэлбэр харьцангуй өөр өөр билээ. Тиймээс сурагчаа сайтар мэдэж таньж, сурагч бүрт тулгарч байгаа асуудлыг хэн хүнээс илүү анги удирдсан багш хүн зайлшгүй мэдэж байх нь чухал юм. Тийм ч учир боловсролын тогтолцоонд заахдаа багш хүнийг хүүхдийн зөвлөгч, чиглүүлэгч бас сайн хамтрагч хэмээсэн байдаг. Сайн хамтрагч байхын тулд хүүхдийг сайтар судалж, түүнд илүү ойр дотно хандах хэрэгтэй. Ийнхүү өнөөгийн нийгэм багш хүнээс судлаач байх чадварыг зайлшгүй шаардаж байгаа. Хэн илүү хөдөлмөрлөнө тэр илүү ихийг хүртэнэ гэдэг шиг өнөөдөр аль багш шавь нарынхаа төлөө цаг зав гаргана тэр багш олон талаараа хөгжжөөс гадна бас олон хүний хайр хүндлэлийг даасан жинхэнэ мэргэжилтэн болж чадна.

Багш эцэг эхтэй байнгын холбоотой ажиллаж хүүхдийн сурч хүмүүжих ахуй нөхцөлийг хангахад анхаарч тэднийг зөв хүн болгон төлөвшүүлэх тал дээр санал, зорилго нэгдэж үйл ажиллагаагаа хамтран явуулж хүүхдийн хөгжил төлөвшилд чиглэсэн үйл ажиллагааг өргөнөөр явуулснаар эцэг эхтэй хамтран ажиллах багш хүний үүргээ биелүүлж чадна. Хүүхдийн төлөөх байгууллага, хувь хүмүүс бүгд хамтарч ажиллахгүй юмаа гэхэд багш эцэг эхчүүд өөрсдөө хүүхдээ төлөвшүүлэхийн тулд хамтын ажиллагаагаа илүү үр дүнтэй болгох аваас бусад хүүхдийн хөгжлийн төлөөх байгууллагуудад үлгэр жишээ үзүүлэгч болох юм. Зөв хөгжил төлөвшил зөв чиглүүлэгчээс эхлэнэ. Тиймээс шинэ эрин зуунд хөгжлийг түүчээлэгч багш хүн өөрөө хамгийн зөв мэргэжилтэн болж мэргэших нь зүйтэй. Нийгмийн орчин нөхцөл маань ирээдүйн багш биднээс дан ганц мэдлэг боловсрол биш ёс зүй, зан суртхуун, харилцааны ур чадвар гэх мэт багш хүнд байх бүхий л цогц чадварыг шаардаж байгаа болохыг багш хүн бүр ойлгох нь чухал болов уу.

Судалгааны хэсэг:

Багш мэргэжилтний ёс зүйн тухай судалгааг асуулга хэлбэрээр өрнүүлж багшийн ёс зүйн талаар үнэлэлт хийсэн билээ.

Судалгаанд оролцсон багш Б: Багш хүн мэргэжлийнхээ үнэ цэнийг ухаарч ажлын байран дээр багш мэргэжлийн ёс зүйг эрхэмлэн сахих ёстой. Ёс зүй гэдэг бол багшийн хөгжлийг илэрхийлэгч тулгуур хүчин зүйл. Ялангуяа өнөөгийн нийгэмд багшийн ёс зүйн тухай асуудлууд маш их хөндөгддөг болсон. Хүүхдийг өөрийн хүүхэд мэт хайрлаж, хамгаалж тэдэнд ухаалгаар аливааг ойлгуулах нь жинхэнэ багшийн хөгжих үйл явц хэмээн дүгнэдэг. Багш хүн мэргэжлийн чиглэлийн мэдлэгээ чадварлагаар ашиглах хэрэгтэй билээ.

Судалгаанд хамрагдсан багш С: Багшийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйл гэхээр хамгаас түрүүн харилцааны чадварын тухай санаанд бууж байна. Ер нь бүх зүйлийн хэм хэмжүүр нь харилцаа, ёс зүй байдаг. Тэр тусмаа амьд харилцаа гэгч зүйл хамгаас чухал. Багш хүн бусадтай эелдэг боловсон харилцаж бүх талаараа үлгэр жишээч байх ёстой.

Судалгаанд хамрагдсан багш Д: Багшийн хөгжилд сургалтын хөтөлбөрөөс гадна ёс зүй, харилцааны соёл, энэрэх хайрлах сэтгэл, ажилдаа хандах хандлага, багийн ажиллагааг эрхэмлэх явдал, судлаач байх чанар, эцэг эх-багш-хүүхдийн гурвалсан холбоог эрхэмлэн ажиллах гэх мэт олон хүчин зүйлсүүд хамаарч тэдгээрээр дамжин багш тасралтгүй хөгжиж байдаг. Багшийн ажлын гол цөм бол ёс зүйтэй байх явдал зайлшгүй мөн.

Судалгаанд хамрагдсан багш Г: Боловсролын салбарын багш мэргэжилтнүүд бид төрийн албан хаагчийн хувьд өөрийн мэргэжлийн үнэ цэнээ ухаарч боловсролын стандартын дагуу чанартай, хүртээмжтэй байдлаар хичээлийг зохион байгуулах ёстой. Сургуулийн насны хүүхдүүдэд түгээмэл тохиолддог зүйл бол танхимын сургалтын үеэр хүүхэд илүү их хөгжиж мөн нийгэмшдэг. Харин цахим сургалтаар хичээллэх болсноос хойш хүүхдүүдийг идэвх оролцоо эрс суларч өмнө нь сурч мэдсэн зүйлээ мартах тохиолдлууд олонтаа ажиглагдсан. Иймээс танхимын сургалтын үед сургалтын төлөвлөгөөг чухалчлан үзэж сургалтаа өрнүүлэх нь зохистой мэт санагдаж байгаа.


Судалгаанд хамрагдсан багш Ц: Багш байна гэдэг маш том үүрэг хариуцлага юм. Багшийн ажилдаа хандах хандлага, нийгэмд үлгэрлэх үлгэр дууриаллаар нийгмийн хөгжил, цаашлаад улс орны хөгжил тодорхойлогдоно. Иймээс багш мэргэжилтэн ёс зүй гэгч зүйлийн мөн чанарын талаар ойлгож ухаарч түүнийг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх учиртай. Дан ганц сургуулийн орчинд ёс зүйтэй байх биш эерэг харилцаа, нэгдмэл байдал, хүнлэг сэтгэл, хүн чанарыг чухалчилсан жинхэнэ багш байснаар ёс зүйтэй багш байж чадна гэж боддог.

Судалгаанд хамрагдсан багш Э: Багшийн ёс зүй гэдгийг нэг үгээр тодорхойлбол асар том соёл юм. Ёс зүйтэй хүнээс соёлтой үйлдлүүд гарна. Мөн

нийгэмд зөв соёлыг түгээж чадна. Багш мэргэжилтэн нь өөр өөрийн мэргэжлийнхээ дагуу сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг өрнүүлдэг хэдий ч ёс зүй гэгч чухал зүйл нь хүүхэд залуус зөв төлөвшил хүмүүжлийг олгоход нэн чухлаар нөлөөлдөг. Хэрвээ багш хүнээс ёс зүйтэй үйлдлүүд гарахгүй бол түмний хүүхдэд зөв үлгэр жишээ болж чадахгүй шүү дээ.


Сургууль дээр хамгийн их ёс зүйн асуудал гаргадаг хүн бэ?

260 хариулт




Багш хувийн үнэлэмжээр сурагчидтай харилцан өөр ханддаг уу.

260 хариулт




Багш анги хамт олон сургуулийн орчинд сурагчийн нэр төрийг гутаах үйлдэл гаргадаг уу.

260 хариулт



Багш сурагчид гар хүрэх үйлдэл гаргадаг уу.

260 хариулт



Судалгааны боловсруулалт: Багш бие хүний үндсэн шинж чанаруудыг эрдэмтэн судлаачид дараах байдлаар авч үзсэн байдаг. Тухайлбал: ажилдаа дур сонирхолтой, идэвхи санаачлагатай, шинийг хийж бүтээх эрмэлзэлтэй, хариуцлагатай, уян хатан сэтгэдэг, ажилдаа сэтгэлээ зориулдаг, шударга, хүмүүнлэг, өөрийгөө эзэмддэг, хянадаг, хурдан сэтгэдэг, аливаад ухаалаг ханддаг, тэвчээртэй хүлээцтэй ханддаг, өөрийн сурган хүмүүжүүлэх үзэл бодол, зарчимтай, шавь нараа чин сэтгэлээсээ хайрладаг, хүндэлдэг, сурагчдад бүх талаараа үлгэр жишээ үзүүлдэг, өөрийгөө дайчилдаг, шаргуу, мэргэжлийнхээ нэр төрийг эрхэмлэдэг, урлаг, спорт гэх зэрэг олон талын мэдлэг чадвартай, хууль журмыг хүндлэн сахидаг, өөрийн эрх мэдлээ урвуулан ашигладаггүй байх зэрэг нийтлэг шаардлагууд тавигддаг. Эдгээр нь уг чанартаа багш хүнийг ёс зүйтэй байдал руу хөтлөх ажгуу.

Багшийн талаар технократ үзэлд багш дуулгавартай гүйцэтгэгч хүмүүсийг бэлтгэх явдал гэж үзээд багш шинжлэх ухаан техник, технологийн туршилтыг сургалтандаа өргөнөөр ашиглэхыг зөвлөдөг бол, хмүүнлэгийн онолд багш бол шударга ёсыг баримтлан тогтоох ёстой. Ингэснээр боловсролын тогтолцоо хүмүүнлэг энэрэнгүй болж үр өгөөж нь дээшилнэ гэж үздэг бол орчин үеийн манай нийгэмд дараах нийтлэг шаардлагуудыг биелүүлхийг багшаас шаардаж байна.

- Багш хүн мэргэжилдээ эзэн байхын хамт хөгжил, төлөвшлийн онол, орчин үеийн сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүйн мэдлэг эзэмшсэн байх, эдгээр мэдлэгийг өдөр дутмын сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэдэг байх, эдгээр мэдлэгийг өдөр дутмын сургалтын үйл ажиллагаандаа бүтээлчээр хэрэглэдэг байх
- Хүүхдэд хайртай түүний төлөвшил сайн сайхны төлөө чадах бүхнээ хийж чаддаг, хүүхдийн төлөө гэсэн сэтгэлтэй, хүүхдийн сурах чадвар, авъяас сонирхол, хэрэгцээнд хүндэтгэлтэй, өөдрөг ханддаг байх, харилцааны өндөр соёлтой, хүүхдийн санаа бодлыг анхааралтай сонсож чаддаг байх
- Багш өөрийнхөө нөөц боломжыг дайчилж, гадаад хэл, компьютер, мэргэжлийн мэдлэг ур чадварыг цаг үргэлж дээшлүүлэн сайжруулж өөрийгөө байнга хөгжүүлэх чадвартай судлаач хүн байх, өөрөө өөртөө шаардлага тавьдаг, өөртөө шүүмжлэлтэй ханддаг алдаа дутагдлаа олж засч чаддаг байх. Багш хүн ажил хэрэгч, нямбай, хариуцлагатай, төлөв даруу, шударга, хэлсэн үгэндээ эзэн болж үг ажил хоёр нь зөрдөггүй байх ёстой. Эдгээр нь жинхэнэ ёс зүйтэй багш байхын суурь чадамжууд юм.

Монгол улсын боловсролын системд шинэ залуу багш нар хүч түрэн орж ирж байгаа тэдгээр нь өмнөх багш нарынхаа алдаан дээр суралцаж дэлхийн жишигт хүрсэн мэрэгжилтэн болохыг хичээж буй. Манай боловсролын тогтолцоо багш төвтэй сургалтаас шавь төвтэй сургалтруу шилжин орж байгаа. Энэ шинэчлэлийн

нэн тэргүүнд багш нар явж, бид өөрсдийгөө хөгжүүлэх орчин үеийн хүүхдүүдийн хэрэгцээ, сонирхолыг харгалзан үзэж өөрсдийн хандлагаа өөрчлөхийг оролдож байна энэ нь маш үр дүнтэй болж байгаа билээ. Гэхдээ багш нь хүүхдэд ганцхан мэдлэг эзэмшүүлэх төдийгөөр хязгаарлагдахгүйгээс гадна бүтээлч хандлагат, ёс зүй, харилцааны соёл, хүүхдэд зөв үлгэр дууриалал болж чаддаг байх ёстой. Ийм ч учраас багш хүн гэдэг ирээдүйн эх ороны эзэдийг бэлтгэж өгдөгөөрөө нийгмийн өмнө онцгой үүрэг хариуцлагатай байдаг.

“Өсвөр залуу үеийг сурган хүмүүжүүлэх, тэднийг амьдралд бэлтгэх хариуцлагатай үүргийг эрт дээр үеэс эцэг эх, овгийн ахлагч, философичид, лам хуврага нар хэрэгжүүлж ирсэн ба сүүлийн нэг зуунд зориуд бэлтгэгдсэн мэргэжлийн багш хэмээх хүмүүс хийх болсон. Багш мэргэжлийг хүндэтгэж, багшын хөдөлмөрийг зөв үнэлэх, багш мэргэжлийн ёс зүйн шалгуур үзүүлэлтийг тодруулхын тулд мэргэжлийн онцлогийг мэдрэх шаардлагатай. Багш хүнд байх ёстой шинж чанрын талаар нэрт сурган хүмүүжүүлэгч эрдэмтэд эртнээс авхуулаад тодорхойлон бичсэн байдаг.

- И.Г.Пасталоцкийн хувьд багш бол “Хүүхдийн цэцэрлэгч”
- Ж.Ж.Руссогийн хувьд “Муу нөлөөнөөс хүүхдийг хамгаалагч манаач”
- П.П.Блонскийн хувьд “Хүн судлалын инженер байх ёстой”
- Я.А.Коменский “Өндөр боловсрол, ёс суртахуунтай, өөрийн үйлсэд үнэнч шударга, ажил хэрэгч, хүүхдэд эцэг ёсоор хайртай зөвхөн тийм л хүн багш байж болох юм” гэдгийг өөрийн бүтээлүүддээ тэмдэглэж байжээ.

Харин гол чиглэлийг удирдсан тодорхойлолт бол В.М.Ломоносов багш хүн бол зөвхөн үгээрээ сургаад зогсохгүй мөн “сайн сайхан үйлсээрээ үлгэр жишээ үзүүлэх ёстой” хэмээн үзсэнд оршино. Нөгөөтэйгүүр Ш.Ичинхорлоо “Өсвөр залуу үеийнхэнд амьдрал ахуйд нь хэрэгтэй мэдлэг, арга барил, чадвар, туршлага олж авхад нь туслах, тэднийг иргэн-бие хүн болон хөгжин төлөвших, нийгэмших ажлыг шинжлэх ухааны үндэстэй зохион явуулах ур чадвар бүхий бие хүн гэж үзэж болно” хэмээн зохиол бүтээлүүддээ тусгасан байна.

Боловсролтой хүмүүсийн хамгийн том төлөөлөл бол төрийн алба хаагч нар байдаг. Гэхдээ боловсролын олон төрөл зүйл дундаас хамгийн чухал нь зүрх сэтгэлийн боловсрол. Төрийн алба хаагч нь ямар ч үед төрийн албан хаагчийн ёс зүйг баримталж эерэг хандлагыг эрхэмлэх ёстой. Хандлага гэдэг нь нөхцөл байдал болон бусад хүмүүсийг тааламжтай ба тааламжгүй аль нэг байдлаар үнэлэх үнэлэлт юм. Харилцаа хандлага хоёр нягт холбоотой бөгөөд харилцааны явцад хандлага мэдрэгддэг. Хандлага үйлдэл болохдоо бодлоор дамжин илэрдэг. Ёс зүй нь хүний дотоод сэтгэлийн төгөлдөршилтэй нягт холбогддог бөгөөд энэ нь харилцаа хандлагын хэлбэрээр илэрнэ. Иймээс төрийн албан хаагчийн хувьд ажлын байр ба бусад ямар ч нөхцөлд эерэг хандлагыг чухалчилж, түүний талаар тодорхой хэмжээний ойлголттой байх нь чухал. Тэгж хэмээн зүрх сэтгэлийн боловсролд төлөвшсөн мэргэжилтэн байж чадах юм.

Хандлага оюун ухаанаас илүү чухал гэж зарим эрдэмтэн судлаачид үзсэн байдаг. Сэтгэл судлаач Карол Двек бүхий л хугацааг хандлага болоод гүйцэтгэлийн талаар судлахад зарцуулсан бөгөөд тэрээр судалгаагаараа хүний амжилтыг IQ биш хандлага тодорхойлдог гэдгийг баталсан нь буй. Хүний хандлагыг хэвшмэл сэтгэлгээ ба өсөлтөт сэтгэлгээ гэж үндсэн хоёр ангилалд хувааж үзсэн бөгөөд хэвшмэл сэтгэлгээтэй хүмүүс өөрийгөө өөрчлөгдөх боломжгүй гэж үнэлжээ. Ямар нэг сорилт бэрхшээл тулгарахад сэтгэлээр унаж цөхөрдөг бол өсөлтөт сэтгэлгээтэй хүмүүс өөрөө хичээвэл өсөж дэвшиж амжилтанд хүрнэ гэдэгт итгэдэг хэмээн дүгнэсэн аж. Хүмүүсийн амьдралдаа хандах хандлага, ёс заншил, уламжлал дэг жаяг, шашин шүтлэг зэргийг хэрхэн авч үзэх нь эцэг эх гэр бүлийн нөлөөлөл, нийгмийн хөгжлийн хандлагаас хамаарч байдаг билээ. Эерэг хандлага байхын адил сөрөг хандлагууд ч бас бий. Иймээс эерэг хандлагыг чухалчилж зүрх сэтгэлийн боловсролыг ямагт эрхэмлэх ёстой.

Дүгнэлт

Орчин үед сургалтын шинэ технологиуд тавигдаж буй шаардлагын дагуу шавь төвтэй, хөгжүүлэх сургалтыг зохион байгуулах шаардлага тавигдаж байна. Хөгжүүлэх сургалтыг хэрэгжүүлэх нэг чухал хүчин зүйл нь багш хүн шавь нараа сайтар судлаж тэдгээрийн хувийн онцлогийг танин мэдэх явдал юм. Учир нь багш хүн, шавь нараа бүхий л талаас нь судалж чаддаг байхын хамт заасан хичээлдээ болон өдөр тутмынхаа үйл ажиллагаандаа олон талын дүн шинжилгээ хийж боловсронгуй болгох, өөрийнхөө мэдлэг, чадварыг өөрөө дээшлүүлэх зэрэг арга барил эзэмшсэн, ном зохиол уншиж судалдаг, ажиглалт судалгаа хийх чадвартай байх ёстой. Багш хүн хэдий чинээ хүүхдийнхээ талаар өргөн мэдлэгтэй тэдний хэрэгцээ сонирхол, хүсэл эрмэлзлийг олж харахыг хичээдэг, хэрэгцээг нь хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж чадвал багш бидний өнөөгийн болон ирээдүйн сайн сайхны төлөө оруулж буй хөрөнгө оруулалт юм.

Багш хүн урлаг, уран сайхан, улс төр, эдийн засаг, спорт гэх зэргийн олон талын өргөн мэдлэгтэй байх зэрэг юм. Орчин үеийн багш нь шавь төвтэй сургалт зохион байгуулж, сурах үйлд сургах нь багшын ажлын чиглэл болоод байна. Багшийн өдөр тутмын сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд байнга нөлөөлөл үзүүлдэг үндсэн объект бол өсөн хөгжиж буй шавь нар нь юм. Багш шавийн сурч хүмүүжих, хөгжин төлөвших үйл ажиллагааг зохион байгуулах, чиглүүлэх, шавийн сурч хөгжих үйл явцыг жолооддог менежер байх хэрэгцээ улам өсөн нэмэгдэж байна. Багшийн ажил нь олон хүүхдийг нэгэн зэрэг хамарч тэдний нүдэн дээр ил явагддаг учир байнга бусдын хараа хяналт дор хэрэгждэг онцлогтой. Багш тун олон янзын зан авиртай шавь нартай ажилладаг учир өөрийгөө байнга эзэмдэх, хэлж буй үг, хийж буй зан үйлээ сайтар хянах, аливаад хүлээцтэй, тэвчээртэй хандах нь мөн энэ мэргэжлийн чухал онцлог юм. Багш сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны

явцад бүх шавь нарыг анхааралдаа багтааж ёс зүйн ур чадварыг гарган ажил үүргээ гүйцэлдүүлэх ёстой ажээ. Багшийн ёс зүй бол нэн түрүүнд тавигдах хамгийн чухал чадварын нэг мөн бөгөөд боловсролын системд хүчтэй нөлөөлөх хүчин зүйл юм.